



МАЖ News

2009 оны 12 дугаар сар

Тусгай дугаар

Гарчиг:

МАЖ-ийн 2009 оны Ажлын Тайлан

МАЖ-ийн Ажлын тайлан	1
2009 Оны Хүн	2
Харшийн Шинэ Жил	3

Монголчуудын Холбоо Япон Ашгийн Бус Байгууллага 2009 оны 1 дүгээр сарын 31-ны өдөр «байгууллага» бүтцэд орж, нэгдсэн зохион байгуулалттай болон Дүрэм, баримт бичгүүдээ боловсруулан, Удирдах зөвлөлөө томилон ажиллан 9 дүгээр сарын 18-нд Ашгийн бус байгууллагаар бүртгүүлж, энэ онд төлөвлөсөн ажлуудаа амжилттай хэрэгжүүлээ. 2009 он МАЖ-ийн хувьд эвсэг хамт олон, эрч хүчтэй багийг бүрдүүлэн, байр сууриа бататгаж, Япон дахь Монголчуудын хамтран ажиллах талбарыг бүрдүүлэхэд чиглэсэн үйлс бүтээлээр дүүрэн жил байлаа.



МАЖ Ньюс : МАЖ-аас хоёр сар тутамд МАЖ Ньюс тогтмол мэдээллийн хуудсыг гаргаж


хүргэж байна.

Тус мэдээллийн сониноор МАЖ-ийн мэдээ, Японы нийгэм эдийн засаг болон өдөр тутмын ахуй амьдралтай холбоотой зөвлөгөө зэргийг нийтэлж байна.



МАЖ Вeb: 2009 оны 4

дүгээр сарын 1-нд МАЖ өөрийн веб хуудсыг нээж ажиллуулж эхэлсэн бөгөөд тус сайтнаас та бүхэн өөрт хэрэгтэй зөвлөгөө, МАЖ-ийн мэдээлэл, Японд Монголтой холбоотой үйл ажиллагааны тухай мэдээ зэргийг авах боломжтой.



Нийгмийн судалгаа: 2009 оны 5 дугаар сард МАЖ Япон дахь Монголчуудын

дунд Нийгмийн судалгаа явуулсан. Уг судалгааны дүнг манай вебсайтад байрлуулснаас гадна Монголын өдөр тутмын Өнөөдөр сонинд мэдээ болон нийтлэгдсэн.

IT мэргэжлийн уулзалт: МАЖ-аас Японд ажиллаж сурч буй



компьютерийн мэргэжилтэн залуусын санал, туршлага солилцох, танилцах, шинэ мэдээлэл мэдээ

хуваалцаж, хамтран ажиллах талбарыг бий болгох зорилгоор 2009 оны 6 дугаар сарын 6-нд мэргэжлийн уулзалт зохион байгуулсан. Тус уулзалтад 30-аад залуус оролцож, мэдлэг туршлагаа хоорондоо солилцож ярилцсан билээ. Удаах уулзалтыг 9 дүгээр сард мөн зохион байгуулсан бөгөөд цаашид энэ уулзалт ирэх жил тогтмол хугацаатай зохион байгуулагдана.



Наадам : Тэмүжин Мура аялал жуулчлалын компанитай хамтран 7 дугаар сард Наадам арга хэмжээг Фүжи уулын бэлд зохион байгуулсан. Эрийн гурван наадмаа наадан нэгэн өдрийг элэг нэгт Монголчуудаараа эх нутагтаа байгаа мэт наадамласан билээ.



Робокон: Токио хотод зохион байгуулагдсан Ази Номхон Далайн Орнуудын Их дээд сургуулийн оюутнуудын дунд болдог Роботын уралдаанд Монголын багаа дэмжин хандивын аян зохион байгуулсан.



Харшийн шинэ жил: Япон дахь Монголчууддаа зориулж МАЖ 2009 оны 12 дугаар сарын 26-нд Ёкохама хотод Харшийн Шинэ

Жилийг зохион байгуулсан.



МАЖ-ийн гишүүнчлэл

Үндсэн гишүүн: -Бүртгэлийн дэлгэрэнгүй хуудсыг бөглөж, жилийн хураамж 10,000 иенийг төлснөөр үндсэн гишүүн болно.

Үндсэн гишүүн холбооны үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, саналаа илэрхийлэх, хяналт тавих, нэгдсэн хуралд оролцож, тэргүүн болон удирдах зөвлөлийн гишүүдийн сонгуульд оролцох, нэр дэвших, дэвшүүлэх, холбооноос эрхлэн гаргах бүх төрлийн мэдээлэл, хурлуудын тайлан, санхүүгийн тайлан зэргийг байнга хүлээн авах, байгууллагаас зохион байгуулах баяр ёслол болон бусад төрлийн үйл ажиллагааны үеэр тусгай хөнгөлөлт эдэлнэ.

Энгийн гишүүн: -Овог нэр, мэйл хаяг зэрэг товч мэдээллээ ирүүлж, жилийн хураамж 2,000 иенийг төлснөөр бүртгэгдэнэ. Энгийн гишүүн нь холбооны мэйлийн сүлжээнд хамрагдаж Холбооноос гаргах мэдээллүүд, мөн гишүүд хоорондоо солилцох мэдээллээс байнга хүлээн авах, байгууллагаас зохион байгуулах баяр ёслол болон бусад төрлийн үйл ажиллагааны үеэр тодорхой хэмжээний хөнгөлөлт эдэлнэ.

МАЖ-аас Япон улсад сурч, ажиллаж амьдарч буй Монголчуудын дунд амжилт бүтээл, ажил хөдөлмөр, сурлага мэдлэгээрээ тэргүүлж, элэг нэгтнүүдийнхээ бахархал болж, сайн үйлсийг дэлгэрүүлэхэд бусдадаа үлгэр дууриал болж буй хүнийг шалгаруулж "Оны онцлох хүн"ээр тодруулах ажлыг анх удаа зохион байгуулаа. Оны хүнээр шалгаруулахад дараах шалгуурыг үндэслэл болгосон.

1. Нийгэм, олон нийт, хүрээлэн буй орчны асуудалд бодитой хувь нэмэр оруулсан
2. Нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан, спорт, соёл боловсролын салбарт амжилт гаргасан, шинэ санаа санаачилга гаргаж хэрэгжүүлсэн
3. Сайн үйлсийг дэмжиж санаачилж зохион байгуулсан, нийтэд тустай үйл хийсэн
4. Япон улсад Монгол улсын нэрийг сайнаар дуурсгах үйлс бүтээсэн

Мөн нэр дэвшсэн хүн тухайн бүтээл ажлаараа төрийн болон олон улсын хэмжээний цол шагнал аваагүй байх шалгуур тавьсан.

Нэр дэвшүүлэн ажлыг Вимо коммьюнити сайт, Амонг электрон шуудангийн сүлжээ, МАЖ-ийн вебсайт, Твиттэр хаягаар тус тус зарласан. Шалгаруулалтыг хоёр үе шаттай явуулсан. Эхний шалгаруулалтаар дээрх шалгуурт нийцэж буй үндэслэлийг тогтоох бөгөөд тус шалгаруулалтаар шалгарсан 5 хүнээс Оны онцлох 3 хүнийг шалгаруулах зарчмаар явуулсан. «Оны хүн» арга хэмжээнд нийт 8 хүний нэр дэвшигдсэн бөгөөд бидний тавьсан шалгуурыг хангасан 5 хүнийг шалгаруулж Харшийн шинэ жил цэнгүүнд урьсан. Эхний шалгаруулалтаар шалгарсан хүмүүст Ж.Бат-Ирээдүй, Б.Тэмүүлэн, Л.Очирхуяг, М.Сугар-Эрдэнэ, Э.Бямбацэрэн нар байлаа. Оны хүн арга хэмжээний шалгаруулах ажлыг МАЖ-аас томилсон баг санал хураалтын журмаар явуулж гүйцэтгэлээ. Тус 5 хүнээс эрдэм судлал, спорт, сайн үйлсийн гэсэн гурван шалгуурт Ажлын хэсэг санал хураалт явуулж дараах 3 хүнийг 2009 оны Оны Онцлох Хүнээр шалгаруулаа:

Ж.Бат-Ирээдүй:

2009 оны эрдэм судлалын салбарт Оны Хүн



2008 оноос Токиогийн Гадаад Судлалын Их сургуульд зочин профессороор ажиллаж буй Ж.Бат-Ирээдүй нь 2009 онд 10 гаруй ном бичиж хэвлүүлэн, Японд байгаа монголчуудын дунд арвин бүтээлтэйгээр хуучин оноо үдэж байгаа хүмүүсийн нэг юм. Хэл шинжлэлийн чиглэлээр дараах бүтээлүүд Монгол хэлний хөгжил, эх хэлээ зөв хэрэглэж суралцахад чухал ач холбогдолтой юм.

1. "Монгол хэлний хоршоо болон давтмал үг хэмээгийн сан" Улаанбаатар., 2009,
2. "Монгол Франц ярианы дэвтэр" Хамтран зохиогч, Улаанбаатар, 2009,
3. "Монгол улсын ерөнхийлөгч Намбарын Энхбаярын үг сэтгэлгээний ертөнц" Улаанбаатар., 2009,
4. "Монгол хэлний сонсох дадлага" CD-тэй ном, I, II дэвтэр, Хамтран зохиогч, Улаанбаатар., 2009,
5. "Монгол хэлний хэлц үгийн сан", Улаанбаатар., 2009,
6. "Монгол газар усны нэрийн сан", Улаанбаатар., 2009,
7. "Монгол хүний нэр, хоч нэрийн сан" Улаанбаатар., 2009,
8. "Монгол хэлний дагавар, нөхцөл баймж үгийн сан", Улаанбаатар., 2009,

9. "Монгол хэлний ерөөл бэлгэ, хараал зүхэл үгийн сан" Улаанбаатар, 2009

Редактораар ажиллаж хэвлүүлсэн ном бүтээл:

1. "АНУ-ын Ерөнхийлөгч Барак Обама, түүний шилдэг илтгэлүүд" CD ном, Б.Номунзул, Улаанбаатар., 2009
2. "Оксфорд Англи Монгол, Монгол Англи халаасны толь бичиг" Адмон компани., 2009,
3. "Монгол хэлний зурган толь бичиг" Б.Батсүх, Улаанбаатар., 2009

Л.Очирхуяг

2009 оны сайн үйлсийн салбарт Оны хүн



Васэдагийн Их Сургуульд Мэдээлэл харилцаа холбооны чиглэлээр Магистрын зэрэг хамгаалахаар суралцаж буй, програмист мэргэжилтэй Л. Очирхуяг нь Я.Цэвэлийн Монгол хэлний тайлбар толь бичгийг онлайн хэлбэрт оруулж, вебсайтад байрлуулах ажлыг санаачилж, дэлхийн өнцөг булан бүрд буй Монголчуудын хүч дэмжлэгтэйгээр богино хугацаанд энэ ажлыг амжилттай хэрэгжүүлсэн үйлсээр Оны хүнээр шалгарсан. Нүүр нүүрээ хараагүй, нэр усаа мэдэхгүй ч олон нийтэд тустай, хэрэг болох зүйлийг санаачилж хийхэд туслах дэмжих, гар бие оролцох сэтгэлтэй залуус олон бийг Л.Очирхуягийн санаачилга нотлохын зэрэгцээ Твиттэр болон блог бусад онлайн сүлжээг сайн үйлсийн санаачилгад амжилттай ашиглаж болохыг харуулж байна.

Я.Цэвэлийн тайлбар толь бичиг онлайн хэлбэрт шилжснээр эх хэлээ бататган суралцах, мэдэхгүй үгээ шууд хайхад тус болоод зогсохгүй Монгол бичгээ хэрэглэж сурахад ач холбогдолтой юм.

Л.Очирхуягийн санаачилж ажилуулж буй вебсайт: <http://toli.query.mn/>

Б.Тэмүүлэн

2009 оны спортын салбар дахь Оны хүн



Япон их сургуульд сурч буй Б.Тэмүүлэн 2008 онд жүдогийн бүх Японы Оюутны аварга шалгаруулах тэмцээнд анх удаа ялсан гадаад хүн бөгөөд Дэлхийн Залуучуудын аварга шалгаруулах жүдо бөхийн тэмцээнд -100 кг жинд хүрэл авчээ. Б.Тэмүүлэн 2009 онд Дэлхийн аварга шалгаруулах жүдогийн тэмцээнд 7 дугаар байр, Ази Тайпэйгийн жүдогийн аварга шалгаруулах тэмцээнд 3 дугаар байр эзэлсэн байн.

Б.Тэмүүлэн ирэх олимпт Монгол улсаа төлөөлж жүдогийн -100 килограммын жинд медалийн эзэн болох найдвар болсон тамирчин юм.



ХАРШИЙН ШИНЭ ЖИЛ



Хөгжөөн баярын дээд, хүүхэд бүрийн хүслэн болон хүлээдэг Шинэ жилийг хамтдаа тэмдэглэж, хамгийн дурсгалтай нэгэн сайхан үдшийг цугтаа өнгөрүүлэе хэмээн МАЖ энэ жил Япон дахь Монголчуудын шинэ жилийн баярыг «Харшийн шинэ жил» нэрийн дор зохион байгуулаа. 2009 оны 12 дугаар сарын 26-нд Ёкохама хотод болсон энэ баярт нийт 250-аад зочид гийчид, бяцхан үрс оролцож, томчуул багачуул хамтдаа баясан, шинэ оноо угтаагаалаа.

Энэ шинэ жилийн баярыг зохион байгуулахдаа МАЖ шинэ жилийн баярыг Монголд болдог шиг орчныг бүрдүүлэх, балчир ахуйдаа бид шинэ жилийг яаж тэсэн ядан хүлээдэг байсан тэр л дурсамжит оройг бяцхан үрсдээ бэлдэх, Японд урлагийн салбарт уран бүтээлээ туурвиж, суралцаж буй залуусаа дэмжин оролцуулах зорилгыг тавьсан билээ. Энэ зорилгодоо хүрч МАЖ анх удаа Шинэ жилийг саруул удаам танхимд, тамхигүй орчинд хийж, Хүүхдийн хөтөлбөрийг тусгайлан хүч гаргаж бэлтгэсэн.



Шинэ жилийн арга хэмжээнд Монгол улсаас Япон улсад суугаа бүрэн эрхэт элчин сайд Р.Жигжид болон Монголын Элчин сайдын яамны төлөөлөгчид хүндэт зочдоор уригдан оролцсон. Монгол, Японы

хүндэт зочид уригдсан билээ.

Цэнгүүнийг МАЖ-ийн тэргүүн У.Өлзийням үг хэлэн нээж, элчин сайд Р.Жигжид мэндчилгээ дэвшүүлэн, хаан бүжиг вальсаар эрхэмсэг үдшийн эхлэлээ. Мөн Япон улсад авъяас чадвараа гайхуулж буй залуу дуучин Хандаагийн дуу цэнгүүний эхлэлийг улам чимж байлаа. Мөн Харшийн шинэ жилийн цэнгүүнд хөөмийч Болд-Эрдэнэ, Beatbox чиглэлийн уран бүтээлч RAY нар хүрэлцэн ирж уран бүтээлээ толилуулав.

Энэ жилийн цэнгүүний нэгэн онцлог үйл явдал бол МАЖ-аас анх удаа Япон дахь Монголчуудын дунд Оны онцлох хүнийг зарласан явдал байлаа. Тус арга хэмжээнд хүмүүс идэвхтэй оролцож, ажил

үйлс бүтээл чадвараар бидний бахархал бас үлгэр жишээ болох хүмүүсийн нэрсийг дэвшүүлж, тэдгээр хүмүүсээс онцлох 3 хүнийг шалгаруулаа.

Монголын сонин хэвлэлд Япон дахь Монголчуудын талаар мэдээ мэдээлэл бэлтгэж, олон нийтэд хүрч ажиллаж буй М.Сугар-Эрдэнэ, Монголд болсон үерийн гамшгийн үеэр хэлмэгдсэн хүмүүст тусламжийн аян зохион байгуулсан Э.Бямбацэрэн, Я.Цэвэлийн толийг онлайн болгох аянг санаачилж гүйцэтгэсэн Л.Очирхуяг нар Оны сайн

үйлстний шагналд, хэл шинжлэлийн салбарт судалгаа шинжилгээ хийж бүтээл гаргасан Ж.Бат-Ирээдүй Оны эрдэм судлалын салбар дахь Оны хүний шагналд, жүдогийн олон улсын тэмцээн уралдаанд өндөр амжилт үзүүлж буй тамирчин, оюутан Б.Тэмүүлэн спортын салбар дахь Оны хүний шагналд тус тус нэр дэвшигдсэн. Үүнээс Л.Очирхуяг, Ж.Бат-Ирээдүй, Б.Тэмүүлэн нар МАЖ-ийн оны хүн шалгаруулах ажлын хэсгийн олонхийн саналаар 2009 ОНЫ ОНЦЛОХ ХҮН-ээр шалгарлаа.



Ж.Бат-Ирээдүй



Л.Очирхуяг

Инээд хөөр цалгисан, энхрий үрс наадан бүжсэн, дуу хуур эгшиглэсэн Харшийн шинэ жилийн хамгийн өхөөрдөм хэсэг Хүүхдийн хөтөлбөр байлаа. Японд буй Монгол хүүхдүүд өөр хоорондоо тэр бүр уулзаж тоглох боломжгүй байдаг ч энэ өдөр эртний найзууд адил хөтөлцөн гүйдэж, хөөрөн баясаж байхыг



хараад эцэг эхчүүд төдийгүй ирсэн зочид гийчдийн хайрыг татаж байв. Гадаад улсад өсөн торниж буй үр хүүхдүүддээ Монгол эх оронтой нь холбох нэгэн шижим болж цэнгүүний нэг хэсгийг бяцхан

үрсдээ зориулан бэлтгэсэн юм. Хүүхдийн хөтөлбөрийн салхийг хагалж Ч.Мичид охин даралтат хөгжмөөр Мэри санно Хицүжи



аяыг даран авъяасаа үзүүлсэн. Өвлийн өвгөн цасан охины хамт танхимд орж ирэхэд хүүхдүүдийн нүд баяраар гэрэлтэн угтаж, цасан охид бүжиглэн эрхэм зочдод бэлэг барьсан. 12 хүүхэд 12 сар болж монгол шүлгээ уншиж, ая дуу дуулан Өвлийн өвгөн аавд авъяас чадвараа харуулав.

Өвлийн өвгөн аав цаг хугацааг ургашлуулан 12 сарын 31 болгож бүгдээрээ хамтдаа 2010 оноо оргилуун дарстай угтан, шинэ оны мэндээ мэндчилж, Сарантуяагийн Шинэ жилийн шөнө дууг дуучин Хандаа дуулан, дараа нь бүгдээрээ Халуун элгэн нутаг дууг хамтдаа дуулж Харшийн шинэ жил өндөрлөсөн билээ.

Удаан уулзаагүй найз нөхөдтэйгээ уулзан учирч, эртний хуучийг дэлгэн, шинэ танил андтай болж, сонин хачинг ярилцан, үр хүүхдүүдээ баярлуулан хөгжөөсөн халуун дулаан Харшийн шинэ жилд ирсэн хэн бүхний сэтгэл өндөр байлаа.

МАЖ-ийн бие даан зохиосон анхны том арга хэмжээ болох энэ Шинэ жилийн цэнгүүн амжилттай болж, ирэх жилдээ Япон дахь Монголчууддаа зориулж улам их хичээн зүтгэж ажиллах хүч урмыг олж авсан юм.

Хүүхдийн зургийн уралдааны бүтээлээс



Содзаяа Такаэ, 3 настай



Н.Хаянхярваа, 6 настай



О.Номин, 8 настай



Ч.Мичид, 9 настай



О.Булган, 9 настай



Тамон, 6 настай